



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 01/10

Ховд

**Дамдинсүрэнгийн Бямбасүрэнг ажлаас чөлөөлж,  
түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Дамдинсүрэнгийн Бямбасүрэнг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Түр орлон гүйцэтгэгчээр томилогдсонтой холбогдуулан Дамдинсүрэнгийн Бямбасүрэнг Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргээс 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Д.Бямбасүрэнг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-10-2 дахь шатлал буюу 926480 төгрөг (есөн зуун хорин зургаан мянга дөрвөн зуун ная)-өөр цалинжуулахыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.


ДАРГА



Д.ЭНХБОЛД

8400 03 0540

Аймгийн Захаг даргын Тамгын газрын  
даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний  
өдрийн Б/40 дүгээр тушаалын хавсралт



## АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

### Ажлын хэсгийн

ахлагч: С.Дорж

Нийгмийн бодлогын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

Гишүүд: Г.Жавзанхорлоо

Нийгмийн бодлогын хэлтсийн  
мэргэжилтэн

Х.Болормаа

Санхүү, аж ахуйн тасгийн нярав

### Нарийн бичгийн

дарга: П.Мандухай

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн  
мэргэжилтэн

-оОо-